

ХУДАЛДААНД ХАМААРАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Гишүүд,

“Хөрөнгө оруулалтын арга хэмжээний худалдааг хязгаарлах болон гажуудуулах үр дагавартай холбогдсон ТХЕХ-ийн зүйлүүдийн үйлчлэлийг судалсны үр дүнд худалдаанд ийм сөрөг нөлөө үзүүлэхийг таслан зогсоохуйц заалтуудыг цаашид хэлэлцэн боловсруулах” талаар Пунта-дель-Эстегийн Тунхаглалд сайд нарын хүрсэн тохиролцоог харгалзаж,

дэлхийн худалдааны тэлэлт болон дэвшилтэт либеральчлалд дөхөм үзүүлэх, худалдаанд оролцогч нийт түншүүд, ялангуяа хөгжиж буй гишүүн орнуудын эдийн засгийн өсөлтийг түргэтгэх үүднээс олон улсын хил хязгаар дамнасан хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, үүний зэрэгцээ чөлөөт өрсөлдөөнийг хангахыг эрмэлзэж,

хөгжиж буй гишүүн орнууд, ялангуяа нэн буурай хөгжилтэй гишүүн орнуудын худалдаа, хөгжил, санхүүгийн тодорхой хэрэгцээ шаардлагыг анхааралдаа авч,

хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээ нь худалдааг хязгаарлах, гажуудуулах нөлөө үзүүлж болохыг хүлээн зөвшөөрч,

үүгээр дараахь зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл *Хамрах хүрээ*

Энэхүү Хэлэлцээр нь зөвхөн барааны худалдаанд холбогдох хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хамаарна (энэхүү Хэлэлцээрт цаашид “ХХХОАХ” гэнэ)

2 дугаар зүйл *Үндэсний нөхцөл болон тоон хязгаарлалт*

1. Ямар ч гишүүн 1994 оны ТХЕХ-т заасан бусад эрх, үүргийг хөндөхгүйгээр 1994 оны ТХЕХ-ийн 3, эсхүл 11 дүгээр зүйлийн заалтад үл нийцэх аливаа ХХХОАХ авахгүй.

2. 1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэсний нөхцлөөр хангах үүрэг болон 1994 оны ТХЕХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тоон хязгаарлалтыг нийтэд нь цуцлах үүрэгт үл нийцэх ХХХОАХ-ний жишиг¹ жагсаалтыг энэ Хэлэлцээрийн Хавсралтад тусгасан болно.

3 дугаар зүйл *Үл хэрэглэх*

1994 оны ТХЕХ-ийн үл хэрэглэх² бүх заалт энэхүү Хэлэлцээрийн заалтуудад зохих ёсоор үйлчилнэ.

4 дүгээр зүйл *Хөгжиж буй гишүүн орнууд*

Хөгжиж буй гишүүн орон 2 дугаар зүйлийн заалтаас түр түдгэлзэх³ эрхтэй бөгөөд чингэхдээ 1994 оны ТХЕХ-ийн 18 дугаар зүйл, 1994 оны ТХЕХ-ийн Төлбөрийн тэнцлийн

¹ **Монгол редакцийн тэмдэглэл:** illustrative

² **Монгол редакцийн тэмдэглэл:** exemption

³ **Монгол редакцийн тэмдэглэл:** deviate

заалтуудын тухай ойлголцлын баримт бичиг, 1979 оны 11 дүгээр сарын 28-нд баталсан Төлбөрийн тэнцлийн зорилгоор авах худалдааны арга хэмжээний тухай тунхаглал (BISD 26S/205-209)-аар 1994 оны ТХЕХ-ийн 3 болон 11 дүгээр зүйлийн заалтаас түдгэлзэж болохыг гишүүдэд зөвшөөрсөн тэр хүрээнд болон арга хэлбэрээр гүйцэтгэнэ.

5 дугаар зүйл

Мэдэгдэл болон шилжилтийн үеийн зохицуулалт⁴

1. Гишүүд ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 90 хоногийн дотор өөрийн хэрэгжүүлж буй, энэхүү Хэлэлцээрийн заалтуудад үл нийцэх бүх ХХХОАХ-ний талаар Барааны худалдааны зөвлөлд мэдэгдэх ёстой. Ерөнхий, эсхүл тусгайлсан байдлаар авч буй тийм ХХХОАХ-г тэдгээрийн үндсэн шинж чанарын тодорхойлолтын хамт мэдэгдэнэ⁵.

2. ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болмогц, дээрх 1 дэх хэсгийн дагуу мэдэгдсэн бүх ХХХОАХ-г хөгжилтэй гишүүн орнууд 2 жил, хөгжиж буй гишүүн орнууд 5 жил, нэн буурай хөгжилтэй орнууд 7 жилийн дотор тус тус цуцлана.

3. Барааны худалдааны зөвлөл нь энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэхэд онцгой бэрхшээлтэй тулгараад байгаа хөгжиж буй, үүний дотор нэн буурай хөгжилтэй улсын хувьд 1 дэх хэсгийн дагуу мэдэгдсэн ХХХОАХ-г цуцлах шилжилтийн үеийн хугацааг тэдгээрийн хүсэлтээр сунгаж болно. Барааны худалдааны зөвлөл эдгээр хүсэлтийг авч үзэхдээ холбогдох гишүүний хөгжил, санхүү болон худалдааны хэрэгцээг нь анхааралдаа авна.

4. Дээрх 1 дэх хэсгийн дагуу мэдэгдсэн аливаа ХХХОАХ-нд ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байсантай нь харьцуулахад 2 дугаар зүйлийн заалттай үл нийцэх байдал нь улам нэмэгдэхүйц аливаа өөрчлөлтийг шилжилтийн хугацаанд хийх ёсгүй. ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болох өдрөөс 180 хоногоос багагүй хугацааны өмнө авч эхэлсэн ХХХОАХ-нд 2 дахь хэсэгт заасан шилжилтийн үеийн зохицуулалтын давуу байдал хамаарахгүй.

5. Гишүүн нь 1 дэх хэсгийн дагуу мэдэгдсэн ХХХОАХ-нд хамаарах тогтвортой ажиллаж буй үйлдвэр, аж ахуйн газрыг ашиггүй байдалд оруулахгүйн тулд шилжилтийн хугацаанд яг тийм ХХХОАХ-г шинэ хөрөнгө оруулалтад 2 дугаар зүйлийн заалтыг харгалзахгүйгээр хэрэглэж болох бөгөөд харин (i) ийм хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн нь тогтвортой ажиллаж буй үйлдвэр, аж ахуйн газрын бүтээгдэхүүнтэй ижил төстэй байх; (ii) шаардлагатай бол шинэ хөрөнгө оруулалт болон тогтвортой ажиллаж буй үйлдвэр, аж ахуйн газрын хоорондох өрсөлдөөний нөхцлийг гажуудуулахаас зайлсхийх шаардлагыг хангасан байна. Шинэ хөрөнгө оруулалтын хувьд ийнхүү авч буй аливаа ХХХОАХ-ний талаар Барааны худалдааны зөвлөлд мэдэгдэх ёстой. Ийм ХХХОАХ-ний нөхцөл нь өрсөлдөөнд нөлөө үзүүлэхийн хувьд тогтвортой ажиллаж буй үйлдвэр, аж ахуйн газрын тухайд хэрэглэж буй нөхцөлтэй адил байх ёстой бөгөөд эдгээр арга хэмжээг нэг дор цуцлах ёстой.

6 дугаар зүйл

Ил тод байдал

1. Гишүүд 1979 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Мэдэгдэл өгөх, зөвлөлдөх, маргаан таслах, хяналт⁶ хийх тухай Ойлголцлын баримт бичиг, мөн 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Мэдэгдэл хийх процедурын талаар Сайд нарын

⁴ **Монгол редакцийн тэмдэглэл:** arrangement

⁵ Шууд эрх мэдлийнхээ хүрээнд авч буй ХХХОАХ-ний хувьд, хэрэгжүүлж буй тухайн тохиолдол бүрт мэдэгдэнэ. Тодорхой үйлдвэр, аж ахуйн газрын хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулахуйц мэдээллийг задруулах шаардлагагүй.

⁶ **Монгол редакцийн тэмдэглэл:** surveillance

гаргасан шийдвэр дэх “Мэдэгдэл өгөх” заалтыг хэрэгжүүлэхдээ 1994 оны ТХЕХ-ийн 10 дугаар зүйлд заасан ил тод байх болон мэдэгдэл өгч байх талаар хүлээсэн үүрэг хариуцлагаа ХХХОАХ-ний хувьд дахин нотолж байна.

2.Гишүүн бүр ХХХОАХ, түүний дотор өөрийн нутаг дэвсгэр дээрх бүсийн болоод орон нутгийн засаг захиргаа, эрх бүхий байгууллагаас авч буй тийм арга хэмжээний тухай мэдээлэл авч болох хэвлэлүүдийн талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

3.Гишүүн бүр энэхүү Хэлэлцээрээс үүдэн гарах аливаа асуудлаар өөр аль нэг гишүүний зүгээс тавьсан мэдээлэл авах хүсэлтэд нааштай хандаж, зөвлөлдөөн хийх зохих бололцоо олгоно. 1994 оны ТХЕХ-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу, мэдээллийг задруулснаар хууль тогтоомж сахиулахад саад болох, эсхүл бусад байдлаар нийтийн эрх ашигт үл нийцэх, төрийн болон хувийн аливаа үйлдвэр, аж ахуйн газрын хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулахаар байвал ийм мэдээллийг ил болгохыг ямар ч гишүүнээс шаардахгүй.

7 дугаар зүйл

Худалдаанд хамаарах хөрөнгө оруулалтын арга хэмжээний асуудал эрхэлсэн хороо

1.Худалдаанд хамаарах хөрөнгө оруулалтын арга хэмжээний асуудал эрхэлсэн хороо (цаашид энэхүү Хэлэлцээрт “Хороо” гэнэ)-г үүгээр байгуулж байгаа бөгөөд Хороо нь бүх гишүүнд нээлттэй байна. Хороо өөрийн дарга, орлогч даргыг сонгох бөгөөд жилд нэгээс доошгүй удаа, эсхүл аль нэгэн гишүүний саналаар үүнээс өөр хугацаанд хуралдана.

2.Хороо нь Барааны худалдааны зөвлөлөөс түүнд хүлээлгэсэн ажил үүрэг гүйцэтгэх бөгөөд энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл, хэрэгжилттэй холбогдсон аливаа асуудлаар зөвлөлдөх боломжийг гишүүдэд бүрдүүлж өгнө.

3.Хороо энэхүү Хэлэлцээрийн үйлчлэл, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд энэ талаар жил бүр Барааны худалдааны зөвлөлд тайлагнаж байна.

8 дугаар зүйл

Зөвлөлдөх, маргаан таслах

Маргаан таслан шийдвэрлэх тухай Ойлголцлын баримт бичгээр дэлгэрүүлэн тодотгосон 1994 оны ТХЕХ-ийн 22, 23 дугаар зүйлийн заалтыг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд зөвлөлдөх, маргаан таслах ажиллагаанд хэрэглэнэ.

9 дүгээр зүйл

Барааны худалдааны зөвлөлөөс хянан хэлэлцэх

Барааны худалдааны зөвлөл нь ДХБ-ын тухай Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос таван жилээс хэтрэхгүй хугацаанд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийн явцыг хянан хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Хэлэлцээрт өөрчлөлт оруулах тухай саналыг Сайд нарын бага хуралд дэвшүүлнэ. Барааны худалдааны зөвлөл нь тийнхүү хянан хэлэлцэхдээ хөрөнгө оруулалтын бодлого болон өрсөлдөөний бодлоготой холбогдсон заалтыг энэхүү Хэлэлцээрт нэмж оруулах шаардлагатай эсэхийг авч үзнэ.

ХАВСРАЛТ
Жишиг жагсаалт

1.1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэсний нөхцлийн тухай үүрэгт үл нийцэх ХХХОАХ-ний тоонд үндэсний хууль тогтоомжийн дагуу, эсхүл захиргааны журмаар заавал биелүүлэх, эсхүл албадан хэрэгжүүлж болох, эсхүл давуу тал олж авахын тулд өөрт нь нийцэж байхыг шаардсан арга хэмжээнүүд, мөн дараахь шаардлага тавьсан арга хэмжээнүүд багтана. Үүнд:

- (a) тодорхой бүтээгдэхүүний хувьд, эсхүл бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ өртгийн хувьд, эсхүл дотоод дахь үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнэ өртөгт тухайн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээний хувьд дотоодын гарал үүсэлтэй, эсхүл дотоодын аливаа эх үүсвэрээс гаралтай гэж тодорхойлогдсон бүтээгдэхүүн худалдан авах буюу ашиглахыг үйлдвэр аж ахуйн газраас шаардсан; эсхүл
- (b) импортын бүтээгдэхүүн худалдан авах болон ашиглахдаа өөрийн экспортод гаргадаг дотоодын бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ өртөгтэй уялдсан хэмжээгээр хязгаарлахыг үйлдвэр аж ахуйн газраас шаардсан.

2.1994 оны ТХЕХ-ийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан тоон хязгаарлалтыг нийтээр цуцлах тухай үүрэгт үл нийцэх ХХХОАХ-ний тоонд үндэсний хууль тогтоомжийн дагуу, эсхүл захиргааны журмаар заавал биелүүлэх, эсхүл албадан хэрэгжүүлж болох, эсхүл давуу тал олж авахын тулд өөрт нь нийцэж байхыг шаардсан, мөн дараахь хязгаарлалт тогтоосон арга хэмжээ багтана. Үүнд:

- (a) үйлдвэр аж ахуйн газраас дотоодын үйлдвэрлэлдээ, эсхүл түүнтэй холбоотой ашиглаж байгаа бүтээгдэхүүний импортыг бүхэлд нь, эсхүл түүний экспортод гаргадаг дотоодын бүтээгдэхүүний тоо хэмжээ, эсхүл үнэ өртөгтэй уялдсан тоо хэмжээгээр хязгаарласан;
- (b) үйлдвэр аж ахуйн газарт орох гадаад валютын орлогын хэмжээгээр гадаад валют худалдан авах боломжийг нь хязгаарлах замаар тухайн үйлдвэр аж ахуйн газраас дотоодын үйлдвэрлэлдээ, эсхүл түүнтэй холбоотой ашиглах бүтээгдэхүүний импортыг хязгаарласан; эсхүл
- (c) үйлдвэр аж ахуйн газраас бүтээгдэхүүн экспортлох, эсхүл экспортод зориулж борлуулахад нь тодорхой бүтээгдэхүүний хувьд, эсхүл бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ өртгийн хувьд, эсхүл дотоод дахь үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнэ өртөгт тухайн бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээний хувьд тавьсан хязгаарлалт.